



944

НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2003 оны 12 сарын 29 өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН  
ГАЗРЫГ ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ

Монгол улсын Иргэний хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4 дэх заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. "Ган хайлш" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

Хоёр. "Ган хайлш" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг энэ оны 12 дугаар сард багтаан зохион байгуулах, өмчийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /М.Энхболд/-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИИН БИЧГИЙН ДАРГА

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД

Т.БИЛЭГТ

Г.МАНАЛЖАВ

П.АЛТАНЦЭЦЭГ  
Т.БАДАМЖУНАЙ  
Д.БААСАНСҮРЭН  
Ц.БААТАРСАЙХАН  
С.НЯМЗАГД  
У.УЛАМБАЯР  
Г.ЭНХТҮҮВШИН

0000622